

Улсын бүртгэлийн
дугаар.....
Аравтын бүрэн
ангиллын код

Нууцын зэрэглэл: А

Төсөл хэрэгжүүлэх
гэрээний дугаар:

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ФИЗИК, ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

ЛАЗЕРЫН СПЕКТРОСКОПЫН ТЕХНОЛОГИЙН СУДАЛГАА

Суурь судалгааны төслийн тайлан
2018-2020

Төслийн удирдагч:

С.Энхбат, доктор (Sc.D), Академич

Санхүүжүүлэгч байгууллага:

Захиалагч байгууллага:

Тайлан өмчлөгч:

Шинжлэх ухаан технологийн сан
Боловсрол, Шинжлэх Ухааны яам
Физик, технологийн хүрээлэн
Энхтайваны өргөн чөлөө, 54Б
Улаанбаатар 13330
Утас: 452819, 99198136
Э-хаяг: senkhat@rocketmail.com

Улаанбаатар

ГАРЧИГ

РЕФЕРАТ.....	3
ТҮЛХҮҮР ҮГ:.....	4
ГҮЙЦЭТГЭГЧДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ:.....	4
ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР.....	4
УДИРТГАЛ.....	5
ЛАЗЕРЫН СПЕКТР СУДЛАЛ.....	6
ЛАЗЕРЫН СПЕКТРОМЕТРИЙН ТӨРЛҮҮД.....	6
Лазерын шингээлтийн спектрометр.....	6
Раман спектрометр.....	6
Хэт хурдан лазерын спектрометр.....	6
Фурье хувиргалттай нил улаан туяаны спектрометр.....	6
ИНТЕРФЕРОГРАМЫН ДОХИОГ БҮРТГЭХ, ДАМЖУУЛАХ ТЕХНИК.....	7
Интерферограм өгөгдөл түүвэрлэлт.....	7
Алхамт-скан ба Үргэлжилсэн-скан.....	8
Түүвэрлэлтийн үе.....	10
Өгөгдөл цуглуулагч.....	11
Өгөгдөл цуглуулагчийн техникийн хэлбэрүүд.....	11
Аналог оролт.....	11
Интерферограмын хэмжилтийн эхлэл.....	12
Спектрийн дохионы дохио-шуугианы харьцаа.....	13
ЛАЗЕРЫН СПЕКТРОМЕТРИЙН ТЕХНИКИЙН ЗАГВАР.....	14
ОПТИК СИСТЕМИЙН ЗАГВАР.....	14
Оптик замын тооцоо.....	14
Хөдөлгөөнт толины удирдлага.....	15
ИНТЕРФЕРОГРАМЫГ БҮРТГЭХ, ХУВИРГАХ.....	20
Детектор.....	20
PDA10D2 детектор.....	20
DET10A2 детектор.....	21
Аналог тоон хувиргуур.....	23
МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ ИНТЕРФЕЙС.....	31
ХҮЛЭЭН АВАХ ПРОГРАМ ХАНГАМЖ.....	32
ТУРШИЛТ БА ҮР ДҮН.....	34
ТУРШИЛТЫН БЭЛТГЭЛ АЖИЛ.....	34
ЛАЗЕРЫН НЭГ ҮҮСГҮҮРИЙН ИНТЕРФЕРОГРАМ.....	38
ЛАЗЕРЫН ХОС ҮҮСГҮҮРИЙН ИНТЕРФЕРОГРАМ.....	40
ДҮГНЭЛТ.....	44
НОМ ЗҮЙ.....	45
ХАВСРАЛТ 1.....	48
ХАВСРАЛТ 2.....	70
ХАВСРАЛТ 3.....	81

РЕФЕРАТ

Суурь судалгааны төслөөр лазер ашигласан спектрометрийн харьцуулсан судалгааг явуулсан. Фурье хувиргалттай нил улаан туяаны спектрометрийн төхөөрөмжийн дохио бүртгэл, боловсруулалтын аргуудыг судалсан ба Майкольсоны интерферометр дээр суурилсан ПЛИС* ашигласан хос лазерын үүсгүүр бүхий спектрометрийг зохион бүтээсэн. Суурь судалгааны төслийн хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэв:

- Лазерын спектрометрийн төхөөрөмжүүдийн хэрэглээ, шаардлага, технологийн боломж зэргийг харьцуулан судалж Фурье хувиргалттай нил улаан туяаны спектрометрийг сонгосон.
- Фурье хувиргалттай нил улаан туяаны спектрометрийн оптик систем, дохио бүртгэх систем болон боловсруулалтын аргуудыг судалж Майкольсоны интерферометр дээр суурилсан спектрометрийн үндсэн элементийн баазыг тодорхойлсон.
- Интерферограмыг бүртгэх аргуудыг харьцуулан судалж үргэлжилсэн-скан хийх аргыг хэрэгжүүлэхэд шаардагдах детектор, түүний гаралтыг хөрвүүлэх аналог тоон хувиргуурын техникийн нөхцөлийг математик семуляц болон туршилтаар тодорхойлсон.
- PIC, Arduino микроконтроллерууд болон Spartan 6 ПЛИС-ийг ашиглан мэдээллийг дамжуулах, урьдчилсан боловсруулалтын програм хангамж бүхий дамжуулах интерфэйсийг зохион бүтээж туршсан.
- Бүртгэсэн интерферограмын боловсруулах, түүнээс спекторыг ялгах програм хангамжийг LabVIEW болон MATLAB програмууд дээр гүйцэтгэсэн.

Дээрх судалгаа туршилтын үр дүнгүүдийг нэгтгэн “RED2” хос лазерын спектрометрийг зохион бүтээсэн. Үүний зэрэгцээ уг төслийн үр дүнд тулгуурлан модульчилсон спектрометрийг бүтээх технологийн суурь судалгааг цаашид гүнзгийрүүлэх ажлын эхлэл болох болно.

*ПЛИС – програмчлагддаг логик интеграл схем

ТҮЛХҮҮР ҮГ: лазер, спектр судлал, интерферограм, интерферометр.

ГҮЙЦЭТГЭГЧДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ:

(овог нэр, эрдмийн зэрэг, цол, албан тушаал)

1. С.Энхбат – доктор (Sc.D), Академич, ЭШТА;
2. О.Бөхцоож – доктор (Ph.D.);
3. Б.Зандан – ЭШДэдА, аспирант;
4. Б.Наранбат – ЭШДэдА, аспирант;
5. Ц.Батцэнгүүн – ЭШДадаА, магистрант;
6. А.Пүрэв-Очир – Инженер;
7. Н.Наранцэцэг – ЭШ-ний туслах ажилтан.

ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР

/техникийн даалгавар/

№	Төслөөр бий болох үр дүн	Тоо хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт	Биелэлт (%)
1	NIR мужийн лазерыг ашиглан, нийлмэл шингэн орчны анализ явуулах судалгаа, туршилт	1	ЭШ-ний өгүүлэл	100
2	Детекторуудыг компьютертай холбох төхөөрөмж, интерфейс, програм хангамжийг судлаж, туршина.	1 1	ЭШ-ний өгүүлэл, төхөөрөмж	100 100
3	Раман спектроскопын төхөөрөмжийн судалгаа хийгдэнэ.	1	ЭШ-ний өгүүлэл	100

УДИРТГАЛ

Лазерын спектр судал гэдэг нь лазерын цацрагийн үүсгүүрүүдийг хэрэглэсэн, спектрийн үзэгдэх болон нил улаан туяаны мужууд дахь спектрийн аргуудын цогц юм.

Өндөр эрчимтэй, монохромат, цацрагийн задрал багатай лазерын цацрагуудыг ашиглах нь спектр судлалын уламжлалт аргуудын боломжийг эрс дээшлүүлжээ. Үүнээс гадна, лазерын хэрэглээ нь физикийн цоо шинэ зарчмууд дээр суурилсан аргуудыг шинээр үүсгэх боломжийг өгсөн ба туршилтын техник ч ихээхэн өөрчлөгдсөн.

Спектрометрийн төхөөрөмжүүдийн ялгах чадвар хэдэн сая дахин өсөж, мэдрэх чадвар нь нэгж атом эсвэл молекулын бүртгэлээр хязгаарлагдсан төвшин хүртэл өссөн ба $10^{-12} - 10^{-14}$ сек хүртэл хугацаанд өнгөрч буй процессуудыг хэмжих боломж бий болсон.

Лазерын спектр судлалын технологи хурдтай хөгжихийн хэрээр үүнтэй холбоотой судалгаа ихээр явагдаж буй боловч манай улсын хувьд энэ чиглэлийн судалгаа, ялангуяа техник, технологи, аргачлалтай холбоотой судалгаа бага байна.

Технологи хөгжихийн хэрээр спектрометрийн төхөөрөмжүүд нь модуль хэлбэртэй болж байгаа нь энэхүү технологийг өөрсдийн боломжид тулгуурлан нэвтрүүлэх боломжийг олгож байна. Мөн спектрометрийн төхөөрөмжүүд нь олон тооны судалгаа, шинжилгээнд хэрэглэгдэж цар хүрээ нь өссөөр байна.

Тус төслийн хүрээнд нил улаан туяаны болон раман спектрометрийн төхөөрөмжүүдийн технологи, аргачлалын судалгааг явуулахаар төлөвлөсөн.

Эдгээр спектр судлалын аргууд, төхөөрөмжийн технологийг судалж, өөрсдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн хэрэгслүүдийг зохион бүтээж сурах нь цаашдаа улсын шинжлэх ухаан, судалгаа, туршилтын ажилд ихээхэн ач тусаа өгөх юм.

ЛАЗЕРЫН СПЕКТР СУДЛАЛ

Спектр судлал гэдэг нь гэрэл бодистой харьцан үйлчлэх үзэгдлийг ашигладаг хэмжил зүйн арга. Лазерыг гэрлийн эх үүсвэр болгон ашигладаг спектр судлалыг лазер спектроскоп эсвэл лазер спектрометр гэж нэрлэдэг. Лазерын спектр судлал нь зөвхөн бодит лазер төдийгүй оптик параметрийн осциллятор, давтамж давхарлагч, ялгаатай давтамж холигч зэрэг шугаман бус давтамж хувиргах төхөөрөмжүүдийн гаралтыг багтаасан лазертай төстэй эх үүсвэрийг ашигладаг гэж ойлгож болно.

ЛАЗЕРЫН СПЕКТРОМЕТРИЙН ТӨРЛҮҮД

Лазерын шингээлтийн спектрометр

Энэ арга нь хамгийн өргөн хэрэглэгддэг арга юм. Энэ аргын үед нарийн зурвасын өргөнтэй, долгионы уртыг өөрчлөх боломжтой лазерыг өөр долгионы уртад шилжүүлэн дээжид тусган хэмжилт хийдэг. Гаргах спектрийн нарийвчлал нь лазерын зурвасын өргөнөөс шалтгаалдаг.

Лазерын шингээлтийн спектрометрийн олон төрөл байдаг. Хэмжилтийн нарийвчлал, мэдрэг чанар зэрэгт үндэслэн тохируулж хэрэглэдэг.

Раман спектрометр

Раман спектрометр нарийн зурвасын үргэлжилсэн долгионы лазер нь зөвхөн ижил оптик давтамжтай гэрлийг цацаргадаггүй гэдэг онолд үндэслэдэг. Раман спектрометрээр молекулын хэлбэлзлийг тодорхойлдог. Энэ аргыг ихэвчлэн тухайн дээжид ямар молекул байгаа вэ? гэдгийг танихын тулд ашигладаг.

Раман спектрометрийг төрөл бүрийн судалгаанд өргөнөөр хэрэглэдэг. Жишээ нь биологи болон анагаах ухаанд, урлагийн бүтээлийн анализ, тэсрэх бодисын илрүүлэлт гэх мэт.


Хэт хурдан лазерын спектрометр

Ихэнх лазерын спектрометрийн техникүүд нь үргэлжилсэн долгионы лазерыг ашигласан байдаг боловч хэт богино импульсийг үүсгэдэг “mode-locked” лазерыг ашигладаг тохиолдлууд байдаг.

Фурье хувиргалттай нил улаан туяаны спектрометр

Фурье хувиргалттай нил улаан туяаны спектрометр нь хатуу, шингэн, хийн шингээлт эсвэл цацаргалтын нил улаан туяаны спектрийг гаргадаг техник юм. Орчин үеийн аналитик химийн лабораториуд бүрд Фурье хувиргалттай нил улаан туяаны спектрометрийг өргөнөөр ашигладаг болсон. Органик нэгдлүүдийн бүтцийн судалгаанд цөмийн соронзон резонанс, масс спектрометр, рентген кристаллографийн багажуудыг ашигладаг. Эдгээрээс нил улаан туяаны спектрометр нь хямд өртөгтэй байдаг. Мөн нил улаан туяаны спектрометр нь дээжид ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй тул үйлдвэрлэлтийн процессыг судлахад үр дүнтэй. Нил улаан туяаны ойрын мужийн спектр нь $800-2600\text{нм}$ долгионы урттай буюу $4000-12500\text{см}^{-1}$ долгион тоо бүхий долгионуудыг хамарна. OH , NH , CH , SH – ийн устөрөгчийн холбоосноос үүссэн агших сунах хэлбэлзлийн бусад мужид гардаггүй спектр нь зөвхөн нил улаан туяаны

ойрын мужид ажиглагддаг ба энэхүү хэлбэлзэл нь маш тодорхой утгыг гаргадаг учир бусад нил улаан туяаны мужаас давуу юм. Мөн $9000 - 15000 \text{ см}^{-1}$ мужид хэд хэдэн электроны шилжилтүүд ажиглагддаг. Полихроматик гэрлийн тархалтын спектрометр нь долгион бүрээр салган хэмжилт хийдэг бол Фурье хувиргалттай нил улаан туяаны спектрометр нь интерферометрийг ашигласнаар энэхүү үйлдлийг хийхгүйгээр нэг л удаа хэмжилт хийх давуу талтай (Зураг 1). Хоёр долгионы интерферометрүүд нь хэрэгцээ шаардлагаасаа шалтгаалан өөр өөр байдаг ч ажиллах зарчим нь ижил. Майкольсоны интерферометр нь энгийн бөгөөд ашиглахад хялбар тул нил улаан туяаны спектрометр хэрэглэхэд тохиромжтой. Майкольсоны интерферометрт цацаргалтын долгионыг хоёр хэсэгт хуваан, хөдөлгөөнт толь хөдөлсний улмаас фазын зөрөө үүссэний дараа хоёр долгионыг буцаан нийлүүлдэг. Үүний үр дүнд интерференц үүсдэг.



Зураг 1. FTIR спектрометрийн зарчим


Алдаагүй спектр гарган авахын тулд хөдөлгөөнт толь нь өндөр нарийвчлалтай буюу ямар ч өөрчлөлтгүй тогтмол хурдаар хөдөлдөг байх ёстой. Үүний шийдэл нь толийг суурьтай нь тогтмол хурдаар хөдөлдөг тавцан дээр байрлуулах. Уг тавцан нь тогтмол хурдтайгаас гадна, хэмжилтийн хугацааг бага байлгахын тулд өндөр хурдтай байх шаардлагатай [1-15].

ИНТЕРФЕРОГРАМЫН ДОХИОГ БҮРТГЭХ, ДАМЖУУЛАХ ТЕХНИК

Интерферограм өгөгдөл түүвэрлэлт

Детекторын бүртгэсэн аналог интерференцийн дохиог тохирох эсвэл урьдчилан тогтоосон оптик замын ялгаврууд дээр барьж тоон дохио болгох шаардлагатай. Интерферограмын өгөгдлийг олж авахдаа тоон импульс “англи хэл *clock*”-ийг үүсгэдэг

дэд системийг ашигладаг. Энэхүү дэд системийг цагийн систем “англи хэл *clocking system*” эсвэл интерферограмын цагийн систем “англи хэл *intreferogramm clocking system*” гэж нэрлэдэг. Зураг 2.а нь цагийн системийн энгийн схемийг харуулсан бол зураг 2.б нь интерферограмыг түүвэрлэх үйл явцыг харуулсан. Хөдөлгөөнт толины байрлалаар синхрончлогдсон тоон импульсийг өгөгдөл цуглуулахад ашигладаг.



Зураг 2. а) Интерферограмын цагийн системийн энгийн схем,

б) Интерферограмыг түүвэрлэх хугацааны диаграмм

d_s - тэнцүү завсартай тоон импульс, Δd_s - нь тоон импульсийн алдаа.


Интерферограм цагийн системийн гурван үндсэн шаардлага байдаг:

- (1) түүвэрлэлтийн болон завсарлагын хугацаа бага байх,
- (2) оптик замын уртын зөрөөний нарийвчлал өндөр байх,
- (3) скан хоорондын давталт өндөр байх.

Алхамт-скан ба Үргэлжилсэн-скан

Интерферограмыг түүвэрлэхдээ алхамт-скан хийх эсвэл үргэлжилсэн скан хийх гэсэн хоёр схемийг ашигладаг (Зураг 3). Алхам алхмаар скан хийх явцад хөдөлж буй толь нь шинэ байршилд шилжиж, өгөгдлийг олж авахаас өмнө зогсдог. Энэ нь спектрийн нарийвчлалын шаардлагыг хангах эцсийн цэгт хүртэл олон удаа давтагддаг. Үргэлжилсэн скан хийж байх үед хөдөлж буй толь нь өгөгдлийг олж авах үед тогтмол хурдтайгаар хөдөлдөг. Хөдөлгөөнт толийг нааш цааш хөдөлгөх шаардлагатай бөгөөд

ижил байрлал дахь өгөгдлийг нэгтгэн дохио-шуугианы харьцааг сайжруулах зорилготой байдаг.



Зураг 3.а) Үргэлжилсэн-сканы үеийн хөдөлгөөнт толины байрлал ба хугацааны хамаарал, б) Алхамт-сканы үеийн хөдөлгөөнт толины байрлал ба хугацааны хамаарал.

Хугацаанаас хамааралтай үзэгдлийн хэмжилтийн хувьд алхам алхмаар скан хийх шаардлагатай байдаг. Ихэнх бусад хэрэглээнд “хурдан” хөдөлгөөнт толийг ашигладаг үргэлжилсэн скан хийх нь давуу талтай байдаг. Хоёр аргын ерөнхий давуу болон сул талуудыг нэгтгэн харуулав (Хүснэгт №1).

Хүснэгт №1

Алхамт-скан (Step-scan)	Үргэлжилсэн-скан (Continuous scan)
Дохио шуугианы харьцааг сайжруулахын тулд тогтмол гүйдлийн дохиог модуляцлах шаардлагатай. Механик таслагч ба түүний электроникт шүүлтүүр ашиглахаас өмнө зурвасын өргөн нарийсах аргыг ашиглах шаардлагатай.	Дохио нь аль хэдийн модуляцлагдсан бөгөөд хөдөлгөөнт толины хурд ба цацрагийн долгионы уртаар тодорхойлогддог давтамжийн хүрээтэй байдаг. Тиймээс зурвасын өргөнийг нарийсгах аргыг шууд ашиглаж болно.
Хэмжилтийн хугацааны урт нь бүртгэлийн давтамж ба хоцролтын зайн хамт пропорционал хэмжээгээр нэмэгддэг.	Ерөнхийдөө илүү хурдан хэмжих хугацаа; хэмжилт хийх хугацааны урт нь хоцрогдсон зайнаас хамаардаг боловч түүврийн давтамжийн шаардлага үүнд нөлөөлөхгүй.
Зөвхөн шүүлтүүр ашиглахаас гадна илүү шуугианыг бууруулах боломжтой механик таслагч, түгжигч өсгөгч детектор ашиглахыг зөвшөөрдөг.	Фурье фильтр гэх мэт шүүлтүүр хийх арга нь илрүүлсэн зурвасын өргөнийг хязгаарладаг боловч шуугиан, үндсэн дохиог тэдний фазад үндэслэн ялгадаггүй.
Цахилгааны саатал, детекторын зурвасын өргөний хязгаараас шалтгаалсан бүртгэх алдаа гардаггүй. Мэдрэгчийн алдаанаас болж бүртгэлийн алдаа гарна.	Цахилгааны саатал, детекторын зурвасын өргөний хязгаараас шалтгаалан бүртгэх алдаа гарч болно; ялангуяа хурдан сканердах интерферометрийн хувьд асуудалтай.

Түүвэрлэлтийн үе

Синусоид дохиог зөв тоон дохио болгохын тулд хамгийн бага түүврийн давтамж f_s нь Найквистын шалгуураар тухайн дохионы давтамжаас хамгийн багадаа хоёр дахин их байх ёстой. Өргөн зурвасын дохионы хувьд хамгийн өндөр давтамж (хамгийн богино долгионы урт) нь Найквистын давтамжийг тодорхойлдог. Өгөгдсөн долгионы уртын λ_0 хувьд конструктив хөндлөнгийн оролцоо нь толин тусгал буурах зайны $\lambda_0/2$ бүрд тохиолддог. Тиймээс долгионы уртын хамгийн бага λ_{\min} агуулсан цацрагийн хувьд интерферограм дахь хамгийн хурдан хувиргадаг дохио нь $\lambda_{\min}/2$ хугацаатай бөгөөд энэ нь $1/2v_{\max}$ -тай тэнцүү юм. Тиймээс Найквистын шалгуурын дагуу түүвэрлэлтийн хугацаа d_s нь дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$d_s \leq \frac{\lambda_{\min}}{4} = \frac{1}{4v_{\max}} \quad (1.1)$$

Үргэлжилсэн скан хийх явцад тоон импульсийн муж дахь түүврийн давтамжийг бас анхаарч үзэх хэрэгтэй. Хөдөлгөөнт толины хурд v -ийн хувьд интерферограм дахь хамгийн их давтамжийг үзүүлнэ.

$$f_{\max} = 2v_{\max} \quad (1.2)$$

Детектор ба электроникийн зурвасын өргөн нь f_{\max} -аас ихээхэн өндөр байх шаардлагатай. Энэ нь Найквистын шалгуураар хугацааны муж дахь түүврийн давтамж нь дараах хэлбэртэй болно.

$$f_s \geq 2f_{\max} = 4v_{\max} \quad (1.3)$$

Тоон импульсийн дохионы хэмжилтийн агшинд тэгийг дайрч байвал интерферограмын далайц нь тэг бүртгэгдэнэ.

Бодит интерферограмын дохио нь зарим шуугианыг агуулдаг. Иймд интерферограмын цагны системийг зохион бүтээхдээ детекторын электроник, үүсгүүр болон орчны нөлөөллөөс үүсэх өндөр давтамжийн шуугианыг анхаарах хэрэгтэй. Үүнийг anti-aliasing шүүлтүүрийг ашиглан арилгах боломжтой. Anti-aliasing шүүлтүүр нь өндөр давтамжийг шүүх аналог шүүлтүүр ба энгийн RC шүүлтүүрийг ашиглаж болно. Шүүлтүүрийн зурвасын өргөн нь Найквистын давтамжаар хязгаарлагдана.

Оптик замын ялгаврын нарийвчлал

HeNe лазерыг түүвэрлэлтийн тоон импульсийг гаргахад ашиглах бөгөөд өөр бусад байрлал тогтоох төхөөрөмжүүдийг ашиглаж болно. Түүвэрлэх давтамж нь өндөр байхаас гадна оптик замын ялгавар нь түүвэрлэх тоон импульстэй өндөр нарийвчлалтайгаар таарч байх шаардлагатай. Түүвэрлэлтийн үед алдаа гардаг ба энэ алдаа нь хөдөлгөөнт толины хурдны өөрчлөлт ба цахилгаан саатлын хосолсон нөлөөнөөс үүсдэг.

$$\Delta d_s = \Delta v \times t_{delay} \quad (1.4)$$

Давтагдах тоон импульсийн байрлал

Үргэлжилсэн скан хийх горимд дохио шуугианы харьцааг сайжруулахын тулд хэд хэдэн интерферограмуудыг нэгтгэдэг. Гэвч дундаж өгөгдлийн цэгүүд нь ижил оптик замын ялгавраас гаралтай байх шаардлагатай.

Техникийн ач холбогдол

Гомодин-лазер интерферометрийн систем нь хөдөлж буй толиор дамжин өнгөрч буй зайтай ойролцоо d_l үеийг харуулсан синусоид дохио үүсгэдэг. d_l -ыг дараах томъёогоор тодорхойлно.

$$d_l = \frac{\lambda_{laser}}{2} \quad (1.5)$$

Өгөгдөл цуглуулагч

Өгөгдөл цуглуулагч (ӨЦ) нь аналог дохиог тоон өгөгдөлд хувиргах, тухайн хувиргасан өгөгдлийг дэлгэцэд харуулах болон цаашдын дохио боловсруулалтад зориулж компьютерт илгээх үүрэгтэй шалгалт, хэмжлийн нэг салбар юм. Өнөөдөр сувгийн тоо, хамгийн их хурд болон нарийвчлал гэх мэтээс хамаарсан төрөл бүрийн хэрэглээнд зориулагдсан янз бүрийн ерөнхий зориулалтын ӨЦ төхөөрөмжүүд байна.

Өгөгдөл цуглуулагчийн техникийн хэлбэрүүд

Дотоод, гадаад гэсэн хоёр үндсэн ӨЦ-ын техник хангамжийн формат байдаг. Гадаад системүүд нь өргөжүүлэх (олон суваг, дохио боловсруулалтад зориулагдсан төхөөрөмжүүд) болон тохиромжтой холболттой байх давуу талтай байдаг. Тиймээс тэд олон оролт, гаралтыг шаардах хэрэглээнүүдэд илүү тохиромжтой байдаг. Нэмэлт ӨЦ нь шууд өгөгдлийн шугамын холболттой байдаг. Тиймээс өгөгдөл дамжуулах өндөр хурдны чадамжтай байдаг. Гадаад төхөөрөмжийн өгөгдөл дамжуулалт нь ихэвчлэн цуваа, зэрэгцээ эсвэл USB дамжуулалтын портоор хязгаарлагддаг.

Аналог оролт

Аналог оролтын авч үзэх шаардлагатай зарим чухал зүйл нь боломжит сувгийн тоо болон хамгийн их хэмжилтийн хурд, тэдгээрийн нарийвчлал (битийн тооноос хамаарсан), өсгөлтийн цар хүрээ (өсгөлт нь програмаар сонгогдох боломжтой эсэх) болон нарийвчлал “*англи accuracy*” юм. Дараах дэд хэсгүүдэд эдгээрийг товч хэлэлцэнэ.

Сувгийн тоо

Фурье хувиргалттай спектрометр нь гол интерферограмыг хэмжихэд хамгийн багадаа нэг суваг шаарддаг. Хэдий тийм ч өргөжүүлэлтэд зориулж нэмэлт сувагтай байх нь тохиромжтой байдаг. Нэмэлт сувгууд нь гэрлийн үүсгүүрийн шилжилтийн засвар болон температурын хэлбэлзлийн засвар гэх мэт засварын техникийг гүйцэтгэхэд шаардагддаг.

Хэмжилтийн хурд

Ихэвчлэн секунд бүр дэх хэмжилтийн нэгжээр өгөгддөг хамгийн их хэмжилтийн хурд нь өгөгдсөн хугацаанд цуглуулах боломжтой өгөгдлийн хамгийн их тоо хэмжээг тодорхойлдог. Техникийн үзүүлэлт нь суваг бүрийн хамгийн их хурдтай холбогддог эсвэл хэрэглэгдсэн суваг бүрээр хуваалцах хамгийн их хурдыг ойлгох нь чухал юм. Хэрэв нэг аналог тоон хувиргуур (АТХ) нь олон тооны сувгаар хуваалцаж буй бол хувиргагч нь сэлгэн залгагддаг. Энэ тохиолдолд суваг бүрийн боломжит хурд нь сувгийн тоонд урвуу хамааралтай байдаг. Жишээлбэл хэмжилтийн хурд нь $1МГц$, 4-н сэлгэн залгах сувагтай бол суваг бүрийн хурд нь $250кГц$ болно. 16 битийн болон бусад дохио боловсруулалтын үйл ажиллагаанаас шалтгаалж хурд нь 10–20мксек болдог.

Аналог тоон хувиргуурын битийн нарийвчлал

Хэрэв АТХ-ыг 12 битийн нарийвчлалаар хэмжилт хийвэл 4096 утга авна. Хэрэв 16 битийн нарийвчлалаар хэмжилт хийвэл 65536 утга авна. 16 битийн хувьд нарийвчлал сайтай боловч хэмжилтийн хурд нь удаан болдог.

Аналог тоон хувиргуурын оролтын хүчдэлийн хэмжээ


ӨЦ-ын оролтын сигналын өсгөлтийг програмын аргаар хялбар хийдэг байх ёстой.

Хэмжилтийн нарийвчлал

Хэмжилтийн нарийвчлал нь LSB буюу АТХ-ын хамгийн бага битийн утгаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл 12 битийн үед $0-5В$ -ын хязгаарт 1LSB нь $0.0012В$ болно. 16 битийн хувьд 1LSB нь $0.000076В$ болно.

Интерферограмын хэмжилтийн эхлэл

Интерферограмын хэмжилтийг хоёр аргаар эхлүүлдэг (Зураг 4). Лазерын тоон импульсээр болон интерферограмын хамгийн их эрчим буюу оптик замын ялгаврын тэг цэг дээрээс эхлүүлнэ. Эдгээр сигналуудыг компаратор төхөөрөмж ашиглан бүртгэнэ.



Зураг 4. Интерферограмын тоон импульсийн болон төвшиний хэмжилт

Спектрийн дохионы дохио-шуугианы харьцаа

Спектрийн дохионы дохио-шуугианы харьцаанд АТХ-ын b битээр авсан интерферограмын дохио шуугианы харьцаа нь дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$SNR_{Digitization}^I = \sqrt{\frac{3}{2}} k 2^b \quad (1.6)$$

Интерферограмаас спектр байгуулах үед дохио шуугианы харьцааг $N_I^{1/2}$ коэффициентоор ихэсгэдэг. N_I нь интерферограмын цэгийн тоог төлөөлдөг.

$$SNR_{Digitization}^S = SNR^I \times N_I^{1/2} \quad (1.7)$$

Монохромат дохионы хувьд спектрийн дохио шуугианы харьцаа нь дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.


$$SNR_{Digitization}^S \approx \sqrt{2} \times SNR^I \times N_I^{1/2} \times \frac{\rho(\nu)}{\rho_{total}} \quad (1.8)$$

$\frac{\rho(\nu)}{\rho_{total}}$ - спектрийн нягтын харьцаа [16-22].

ЛАЗЕРЫН СПЕКТРОМЕТРИЙН ТЕХНИКИЙН ЗАГВАР

ОПТИК СИСТЕМИЙН ЗАГВАР

Майколсоны интерферометр бүхий спектрометрийн төхөөрөмжийн гол төлөөлөл нь Фурье хувиргалттай спектрометрүүд байдаг ба өргөн тархсан хэлбэр нь Фурье хувиргалттай ойрын мужийн нил улаан туяаны спектрометр юм. Иймд судалгаа туршилтын спектрийг бүртгэх төхөөрөмжийн оптик системийн загварыг боловсруулсан (Зураг 5) .



Зураг 5. Майколсоны интерферометр бүхий нил улаан туяаны ойрын мужийн спектрометрийн оптик системийн схем

Оптик замын тооцоо

Хүнхэр толины фокусын зай нь 25мм боловч нил улаан туяаны гэрэл нь перпендикуляраар тусаагүй үед толины фокусын зайг тодорхойлох шаардлагатай. Тиймээс симуляци хийн толины байрлал болон тухайн толиноос ойсон гэрлийн чиглэл зэргийг тодорхойлсон. Парабол толины хувьд 1016 мм-ийн ойлтын фокусын зайтай 45° налуутай толь сонгосон. Энэхүү толины хувьд ойлтын фокусын зайг тооцож парабол толины өмнөх болон дараах элементийн байрлалыг тодорхойлох шаардлагатай. Мөн эхний удаад багажаа угсрахдаа зайг хэт шахуу биш байлгахыг зорьсон. Дээрх бүгдийг үндэслэн нил улаан туяаны ойрын мужийн спектрометрийн оптик системийн загварыг Зураг 5 дээрх байдлаар гаргасан.

Нил улаан туяаны ламп SLS202L/M – ийн оптик чадал нь 400мВт . Ашиглаж буй детектор нь хамгийн ихдээ, өөрөөр хэлбэл ханалтын чадал нь 1.2мВт . Хэрвээ ханалт үүсвэл детектор эвдрэх болно. Тиймээс лампын гаралтын 400мВт чадлыг детектор дээр очихдоо 1.2мВт хүртэл бууруулах шаардлагатай. Иймээс загвар дээрээ гэрлийн “Урвуу квадрат хууль”-ийг ашиглан детекторт ирэх чадлыг тооцоолсон.

Нил улаан туяаны гэрлийн гаралтаас эхний хүнхэр толь хүртэл зай 230мм . Үүн дээр урвуу квадрат хуулийн тэгшитгэлийг бичвэл:

$$400\text{мВт} \cdot (110\text{мм})^2 = p_1 \cdot (340\text{мм})^2 \rightarrow p_1 = 41.87\text{мВт} \quad (1.9)$$

Энэ нь эхний хүнхэр толь дээр нил улаан туяаны гэрэл нь 41.45мВт чадлаар тусаж байна гэсэн үг юм. Хүнхэр толины ойлгох чадвар нь хамгийн ихдээ 99% тул $41.87\text{мВт} \cdot 0.99 = 41.45\text{мВт}$ чадлаар ойлсон гэрэл тусна. Энэ мэтчилэн оптик элементүүдийн ойлт нэвтрүүлэлтийн хувийг тооцоолон детектор дээр ирэх чадлыг тооцоход 1.22мВт гарсан [23-25].

Хөдөлгөөнт толины удирдлага

Майкольсоны интерферометрийн интерферограм үүсэх процессыг динамикаар удирдах боломжийг олгож буй хэсэг нь хөдөлгөөнт толины шилжилт юм. Иймээс хөдөлгөөнт толийг харьцангуй жигд хурдаар өндөр нарийвчлалтай хөдөлгөх зорилгоор DDSM50/M маркын шугаман хөтлөгчтэй тавцан (ШХТ)-г ашигласан (Зураг 6).



Зураг 6. DDSM50/M маркын шугаман хөтлөгчтэй тавцан

DDSM50 маркын ШХТ нь 500нм нарийвчлалтай, хамгийн ихдээ 500мм/сек хурдтайгаар 50мм шилжилт хийх боломжийг олгодог. Мөн KBD101 сойзгүй моторын удирдлага болон “Thorlabs APT, Kinesis” зэрэг програм хангамжийн интерфэйсийн хамт “plug and play” системийг бүрдүүлдэг. Иймээс уг систем нь гэрлийн интерферограмыг үүсгэхэд хэрэглэгдэх толины хөдөлгөөнийг компьютераас удирдах боломжийг олгож байна.


Сойзгүй тогтмол гүйдлийн моторын KBD101 K-Cubes удирдлагыг өндөр хурд ($>100\text{мм/сек}$) болон өндөр нарийвчлалтай энкодер ($<100\text{нм}$) шаардлагатай хөдөлгөөнийг удирдахад хэрэглэгддэг (Зураг 7).




Зураг 7. KBD101 маркын тогтмол гүйдлийн сойзгүй моторын удирдлага

KBD101 удирдлага нь USB 2.0 портоор компьютерт холбогддог ба тогтмол гүйдлийн 15В, 1А тэжээлийн блокоор тэжээгддэг. Өөр дээрээ хурд, алхам болон бусад тохируулгыг хийх удирдлага, хяналтын дэлгэцийг агуулдаг.


ШХТ-ын удирдлагын програмыг “Thorlabs APT, Kinesis” интерфэйсийн санг ашиглан LabVIEW програм дээр “ActiveX control” болон “.NET framework” гэсэн системийн интерфэйсийн хоёр хувилбараар боловсруулан удирдлагын функцүүдийг туршсан (Зураг 8, 9).




Зураг 8.а) “ActiveX control” бүхий удирдлагын програмын блок схем



Зураг 8.б) “ActiveX control” бүхий удирдлагын програмын интерфэйс



Зураг 9.а) “.NET framework” бүхий удирдлагын програмын блок схем



Зураг 9. “.NET framework” бүхий удирдлагын програмын интерфэйс

Цаашид судалгаа туршилтын ажилд “.NET framework” дээр суурилсан удирдлагын програм хангамжийг ашиглахаар сонгосон [26-29].

Шугаман хөтлөгчтэй тавцангийн хэлбэлзэл

Интерферометрт ашиглах ШХТ алдааг шалгах болон долгион хуваагчийн ажиллагааг судлах туршилт хийсэн. DDSM50/М ШХТ-ын хурдыг 0.001мм/сек, 0.01мм/сек, 0.1мм/сек байх үед өгөгдсөн замыг туулах хугацааны тооцооны болон туршилтаар хэмжсэн утгуудыг харьцуулсан (Хүснэгт №2).

Хүснэгт №2.

Зам $S(мм)$	Хурд $V(мм/сек)$	Хугацаа		Алдаа (%)
		Тооцоо $t_{тооцоо}(сек)$	Туршилт $t_{туршилт}(сек)$	
1.0	0.001	1000.0	1343.0	34.3
1.0	0.01	100.0	103.0	3.0
1.0	0.1	10.0	10.0	0.0

Долгион хуваагчид ирж буй болон түүгээр хуваагдсан гэрлийн эрчмийн тодорхойлох зорилгоор долгион хуваагч, хөдөлгөөнт болон хөдөлгөөнгүй толины

байршил дээр ирж буй гэрлийн эрчмийг PDA10D2 детектор ашиглан MDO-2072EX осциллоскопоор хэмжсэн (Хүснэгт №3).

Хүснэгт №3

Гэрлийн чиглэл	Гэрлийн далайц $U(B)$	
	1-р хэмжилт	2-р хэмжилт
Долгион хуваагчруу ирж буй	6.0	6.0
Хөдөлгөөнт толируу ирж буй	3.2	3.1
Хөдөлгөөнгүй толируу ирж буй	3.3	3.2


ИНТЕРФЕРОГРАМЫГ БҮРТГЭХ, ХУВИРГАХ

Детектор

Интерферограмыг бүртгэхдээ PDA10D2 болон DET10A2 маркын детекторуудыг ашигласан. PDA10D2 детектор нь 900–2600нм, DET10A2 детектор нь 200–1100нм мужид мэдрэх чадвартай фото диодыг агуулсан байдаг. Эдгээр детекторуудын техникийн үзүүлэлтийн тухай хураангуйлан тодорхойлбол [30]:

PDA10D2 детектор

PDA10D2 нь 900–2600нм мужид гэрлийг мэдрэх зориулалттай Индиум галлийн арсенид (*InGaAs*) детектор. Энэхүү детекторын гаралтыг 500м-ын коаксиал кабелиар осциллоскоп болон аналог тоон төхөөрөмжид холбон ашиглаж болдог. Энэ үед гаралтын хүчдэл нь 0–5В байдаг. Хэрэв хүлээн авах төхөөрөмжийн оролтын эсэргүүцэл нь 500м-оос их бол детекторын гаралтын хүчдэл нь 0–10В болдог. PDA10D2 нь PIN фото диод болон урвуу чиглэлтэй дохио өсгөгч хэлхээг өөртөө багтаасан байдаг (Зураг 10).



Зураг 10. PDA10D2 детекторын дотоод бүтцийн схем.


Фотодиодын мэдрэлт нь өгөгдсөн долгионы уртад харгалзан диодын үүсгэсэн фотогүйдэл I_{PD} болон туссан гэрлийн эрчмийн P харьцаагаар тодорхойлогдоно.

$$R(\lambda) = \frac{I_{PD}}{P} \quad (1.10)$$

Мэдрэгчийн өсгөлт нь гэдрэг холбооны эсэргүүцлээс R_F хамаарах ба зурвасын өргөн нь дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$f(-3dB) = \sqrt{\frac{GBP}{4\pi R_F \times C_D}} \quad (1.11)$$

Энд GBP нь өсгөлтийн зурвасын өргөн, C_D нь фотодиодын шилжилтийн болон өсгөгчийн багтаамжийн нийлбэр.



Зураг 11. PDA10D2 детекторын долгионы уртаас хамаарсан мэдрэх мурий.

PDA10D2 детекторын техникийн үзүүлэлтийг Хүснэгт №4-д үзүүлэв [31].

Хүснэгт №4.


Мэдрэгчийн материал	Индиум галлийн арсенид
Талбай	Ø1.0мм(0.8мм ²)
Долгионы урт	900 – 2600нм
Хамгийн өндөр утгад харгалзах долгионы урт	2300нм
Шуугианы үйлчлэх утга (RMS)	2.5мВ
Гаралтын гүйдэл	100мА
Ачааны гаралтын бүрэн эсэргүүцэл	> 50Ом
Гаралтын хүчдэл	0 – 5В(50Ом) 0 – 10В(> 50Ом)

DET10A2 детектор


DET10A2 детектор нь 200–1100нм хүртэлх гэрлийн дохиог хүлээн авах зориулалттай цахиуран (Si) детектор. Уг детектор нь 12В батарейгаар ажилладаг тул тэжээлийн үүсгүүрээс ирэх шуугианаас тусгаарлагдаж чаддаг. DET10A2 детектор нь батарей тууль хамгаалалтын диод, хүчдэл тогтворжуулагч, RC шүүлтүүр болон фото диодыг агуулсан байдаг (Зураг 12).

DET10A2 детектор нь зураг 12-т үзүүлсэн схемийн дагуу гэрлийг цахилгаан дохионд хувиргана. Детекторын мэдрэгч элемент нь гэрлийг фотогүйдэлд хувиргана.

Үүссэн фотогүйдэл нь туссан гэрлийн эрчим ба долгионы уртаас хамаарна. RC шүүлтүүр нь оролтын өндөр давтамжийн шуугианыг шүүнэ.



Зураг 12. DET10A2 детекторын дотоод бүтцийн схем.



Зураг 13. DET10A2 детекторын долгионы уртаас хамаарсан мэдрэх мурий.

DET10A2 детекторын техникийн үзүүлэлтийг Хүснэгт №5-д үзүүлэв.

Хүснэгт №5.

Мэдрэгчийн материал	Цахиур
Талбай	$\varnothing 1.0 \text{ нм} (0.8 \text{ мм}^2)$
Долгионы урт	200–1100 нм
Хамгийн өндөр утгад харгалзах долгионы урт	730 нм
Харанхуйн гүйдэл	Дундаж – 0.3 нА Хамгийн их – 2.5 нА
Шилжилтийн багтаамж	6 нкФ

Хүчдэл	10В
Гаралтын гүйдэл	0–10мА

DET10A2 детектор нь батарейнаас тэжээгддэг тул батарейн хүчдэлийг хэмжих шаардлагатай. Дээрх үйлдэлд зориулсан батарей шалгах товчлууур детектор дээр байх ба түүнийг ашиглан гүйцэтгэнэ. Шалгалтын үр дүн нь батарейн хүчдэлтэй харгалзах хүчдэл детекторын гаралтад гарна. Энэ нь дараах тэгшитгэлээр илэрхийлэгддэг.

$$U_{\text{гар}} = U_{\text{бат}} \left[\frac{R_{\text{ачаа}}}{R_{\text{ачаа}} + R_{\text{хяз}}} \right] \quad (1.12)$$


Энд: $U_{\text{гар}}$ -гаралтын хүчдэл, $U_{\text{бат}}$ -батарейн хүчдэл, $R_{\text{ачаа}}$ -ачааны эсэргүүцэл, $R_{\text{хяз}}$ - гүйдлийн хязгаарлагч эсэргүүцэл [32].

Жишээ: $U_{\text{бат}} = 9В$, $R_{\text{ачаа}} = 500Ом$, $R_{\text{хяз}} = 25400Ом$ бол $U_{\text{гар}} \approx 0.17В$ болно.

Аналог тоон хувиргуур

PDA10D2 болон DET10A2 детекторуудын гаралтын дохионы хэлбэр болон төвшинд үндэслэн 0–10В оролттой АТХ ашиглах шаардлагатай. АТХ-ын оролтын суваг нь 1-4, 10-16 битийн тоон гаралттай, дотоод өсгөлт нь 1-8, I2C, SPI, RS232, USB гэх мэт цуваа болон 8-16 битийн зэрэгцээ дамжуулалттай байж болно [35-36].

MATLAB програм дээр АТХ –аас дохио хүлээн авах симуляцыг хийж гүйцэтгэсэн. Симуляцид МСР3428 загварын дельта-сигма АТХ –ын 12 битийн тоон гаралт, 240SPS хэмжилтийн хурд зэрэг үзүүлэлтүүдийг тохируулсан. Симуляцаар 900, 1000, 1100, 1200, 1300нм урттай долгионуудын интерферограм болон түүнээс Фурье хувиргалт ашиглан спектрийг гарган авсан (Зураг 14).



Зураг 14. 900-1300нм интерферограм болон спектрууд

632.8nm долгионы урттай лазерын интерферограмыг бүртгэн авахын тулд 240SPS хурдтай АТХ ашиглах тохиолдолд ШХТ-ын хурдыг 0.1, 0.01, 0.001мм/сек -ээр сонгох үед бүртгэн авах цэгийн тоог тодорхойлсон (Хүснэгт №6).

Хүснэгт №6

ШХТ-ын хурд V (мм/сек)	Интерферограмын үе T (млсек)	АТХ-ын бүртгэх цэгийн тоо
0.001	316.4	76.0
0.01	31.64	7.6
0.1	3.164	0.76

Дээрх хүснэгтээс харахад 240SPS хурдаар өгөгдлийг хувиргадаг АТХ ашиглавал ШХТ-ыг 0.01мм/сек -ээс бага хурдтай хөдөлгөх шаардлагатай нь харагдаж байна.

Гэвч туршилтаар 0.01мм/сек -ээс бага хурдаар ШХТ-г хөдөлгөх үед дохионы шилжилтийн үргэлжилсэн байдал алдагдаж байгаа нь ажиглагдсан (Зураг 15).



Зураг 15. 0.01мм/сек -ээс бага хурдтай хөдөлгөх үед үүссэн алдаа.

Тиймээс ШХТ-г 0.01мм/сек -ээс дээш хурдтайгаар хөдөлгөх ба АТХ нь 12 битийн 240SPS -ээс дээш хурдтай бүртгэдэг байх шаардлагатай байна.

Хэрэв дохионы нэг бүтэн үеэс хамгийн багадаа 20 утгыг бүртгэнэ гэвэл дараах томъёог ашиглан шаардлагатай АТХ-ын хурдыг тооцоолно.


$$SPS = \frac{20}{T} = \frac{20}{31.64 \cdot 10^{-3}} = 632SPS \quad (1.13)$$

Энд T нь дохионы үе болно.

Дээрх тооцооны үр дүнд ШХТ-ыг 0.01мм/сек хурдтай хөдөлгөх үед АТХ нь хамгийн багадаа секундэд 632 утга бүртгэдэг байх шаардлагатай байна.

МСР3428 АТХ нь 240SPS буюу шаардагдах хурднаас 2.6 дахин бага тул интерферограмыг богино хугацаанд алдаа багатай бүртгэх тохиолдолд ашиглах боломжгүй байна.

Гэвч 240SPS үзүүлэлттэй АТХ-ыг ашиглан интерферограмыг сэлгэн бүртгэхэд шаардлагатай хэмжилтийн тоог MATLAB програм дээр тооцоолсон. Тооцооны үр дүн нь 8192 гэж гарсан. Энэ нь нэг бүтэн үеийг хэмжихэд 32 секундийн хугацаа шаардлагатай. Тооцооны үр дүнгийн график (Зураг 16).



Зураг 16. 900-1300нм нил улаан туяаны интерферограмыг хэмжихэд шаардлагатай хэмжилтийн тоог тооцоолсон график

Дээрх үр дүнг бодит систем дээр ажиллуулахад МСР3428 АТХ, Arduino Due микроконтроллерыг ашиглахаар тооцоолон Arduino болон LabVIEW програм дээр програмчилсан.

Arduino due нь 8192 ширхэг 16 битийн утгуудыг дамжуулах шаардлагатай ба ингэхийн тулд нэмэлт ялгах байтуудыг нэмснээр 122880 байт-ыг 115200 бум/сек

хурдаар дамжуулах програм бичив. Энэ хурдыг ихэсгэх шаардлагатай. Зураг 17-д програмын кодын хэсгийг харуулав.



```

1 // MCP3428 ATX удирдах програм Arduino Due 28
2 #include <Wire.h> 29
3 #define I2C_ADDR 0x68 30
4 unsigned int data[3]; 31
5 unsigned long time1, time2, time3; 32
6 int raw_adc; 33
7 int result_mat[8192]; 34
8 int flag=0; 35
9 int flag2=0; 36
10 void setup(){ 37
11 Wire.begin(); 38
12 Wire.setClock(400000); 39
13 Serial.begin(115200); 40
14 Wire.beginTransmission(I2C_ADDR); 41
15 delay(1000); 42
16 } 43
17 void loop(){ 44
18 Wire.beginTransmission(I2C_ADDR); 45
19 Wire.write(0x10); 46
20 Wire.endTransmission(); 47
21 time1=millis(); 48
22 flag2=0; 49
23 int kk=500; 50
24 for(int i=0;i<kk;i++){ 51
25 do{ 52
26 | flag=0; 53
27 | data[0]=0; 54
28 | data[1]=0;
29 | data[2]=0;
30 | Wire.requestFrom(I2C_ADDR,3);
31 | int lp=0;
32 | while(Wire.available())
33 | { data[lp]=Wire.read();
34 | | lp++;
35 | }
36 | flag=data[2]&0x80;
37 | if(data[2]==0){
38 | flag2++;
39 | Wire.begin();
40 | Wire.beginTransmission(I2C_ADDR);
41 | Wire.write(0x14);
42 | Wire.endTransmission();
43 | delay(1);
44 | flag=0x80;
45 | }
46 | }while(flag==0x80);
47 | raw_adc=(data[0]&0xFF)*256+data[1];
48 | result_mat[i]=raw_adc;
49 | }
50 | Serial.print('B');
51 | for(int i=0;i<kk;i++){
52 | Serial.print(result_mat[i],DEC);
53 | Serial.print(',');
54 | }

```

Зураг 17. Arduino-д бичсэн програмын код


Arduino due-аас компьютерт ирэх мэдээллийг хүлээн авах, боловсруулах програмыг LabVIEW-д бичсэн. Энэ програм нь цуваа байтаар өгөгдлийг хүлээн авч, зохимжтой тоон утгаруу шилжүүлэн, хадгалах мөн графикаар үзүүлэх үүрэгтэй. Зураг 18-д програмын кодын хэсэг болон интерфэйсийг харуулав.



Зураг 18. LabVIEW-д бичсэн програмын интерфейс болон блок диаграм


Бага хурдтай АТХ-ыг ашиглах тохиолдолд дээрх шийдэл нь хэрэглэгдэж болох боловч өндөр хурдтай тооцооллын хэрэглээнд тохиромжгүй юм.

Өндөр хурдтай тооцооллын үед ШХТ-г 0.01 мм/сек -ээс дээш хурдаар хөдөлгөх шаардлагатай. Энэ үед интерферограмын нэг үеийг хэмжихэд 632 SPS -ээс дээш хурдтай АТХ-ыг ашиглах шаардлагатай ба AN7606 АТХ нь 200 kSPS хурдтай тул дээрх хурдыг бүрэн хангаж байна (Зураг 19).




Зураг 19. AD7606 ATX-ын схем.

АТХ-ын ажиллагааны нэн чухал ойлголт нь хүлээн авсан дохиог хувиргах хугацааны диаграмм байдаг (Зураг 20). Хугацааны диаграммын дагуу удирдлагын дохиог зөв тохируулснаар алдаагүй үр дүнг хүлээн авдаг.



a)



b)


Зураг 20. AD7606 ATX-ын хугацааны диаграмм. а) хувиргалт хийсний дараа уншилтыг гүйцэтгэх, б) хувиргалтыг хийх үед уншилтыг гүйцэтгэх.

Дээрх диаграммаас харахад RESET оролт нь тухайн ATX-ын региструудийн утгыг анхны утгад оруулдаг оролт. CONVST A ба CONVST B нь хувиргалтыг эхлүүлдэг оролтууд. CONVST A нь 1,2,3,4-р сувгуудын хувиргалтыг эхлүүлэх оролтуудыг харин CONVST B нь 5, 6, 7, 8-р сувгуудын хувиргалтыг эхлүүлэх оролтууд юм. CS оролт нь хувиргасан өгөгдлийн дамжуулалтыг зөвшөөрдөг оролт юм. Мөн BUSY гаралт нь логик 1 бол хувиргалт гүйцэтгэгдэж буйг харуулна. Үүнээс гадна DB[0:15] хөл нь өгөгдлийнх бөгөөд эдгээр хөлөөр хувиргасан 16 битийн өгөгдлийг хүлээн авна.

Интерферограмын дохиог бүртгэхэд AN7606 ATX-т суурилан бүтээгдсэн AN706 ATX-ын модулийг ашигласан (Зураг 21).

AN706 ATX-ын модулийн техникийн үзүүлэлт:

- $\pm 10V$, $\pm 5V$ хоёр туйлт аналог оролттой,
- $1M\Omega$ оролтын эсэргүүцэлтэй,
- 12, 14, 16 битийн хувиргалттай,
- $200kSPS$ хурдтай,
- Тэжээлийн хүчдэл $5V$,
- 8 сувагтай.



Зураг 21. AN706 аналог тоон хувиргуурын модуль.

Зураг 21-ын зүүн талын зураг дээрх микросхем нь AN7606 ATX болно. Энэ модуль нь AN7606-г тэжээх тэжээлийн хэсэг, ажиллуулахад шаардлагатай бусад электроникийн элементүүд болон гадаад төхөөрөмжийн оролт гаралтуудыг багтаасан байдаг. Мөн аналог дохиог тоон хэлбэрт хувирган гаралтын өгөгдлийг 16 битээр зэрэгцээгээр дамжуулна.

AN706 ATX-ын модуль нь ALINX AX309 ПЛИС* хавтантай зохицон ажиллах боломжтой. ALINX брэндийн AX309 хавтан нь хямд үнэтэй, бага чадлын XILINX SPARTAN-6 хөгжүүлэгч хавтан юм. Энэхүү хавтан нь дараах бүрдэл хэсгүүдийг агуулдаг. Үүнд:

- Xilinx Spartan-6 XC6SLX9 ПЛИС процессор
- On-board JTAG програмчлалын порт
- 256Мбит SDRAM санах ой
- 64Мбит SPI FLASH санах ой
- 5000000 pixels OV5640 камерын модулийг дэмжих порт
- 4 товчлуур, 4 LED гэрэл, 6 7-сегментийн индикатор, 1 хонх
- 50МГц осциллятор
- RTC цагийн модуль
- 24LC04 EEPROM санах ой
- VGA модуль
- 1.2В, 5В, 3.3В тэжээлийн үүсгүүр
- On-board USB-RS232 модуль
- 2 ширхэг 40 хөлтэй өргөтгөлийн порт


AX309 хавтан нь хэмжилтийг гүйцэтгэн, өөр дээрээ хэмжилтийн утгыг буферлэн хадгална. Эдгээр утгыг компьютерт дамжуулна. Дээрх жагсаалтаас харахад дотоод синхронжих импульс нь 20нсек-ын үетэй. AX309 хавтангын харагдах байдлыг Зурагт 22-д үзүүлэв.



Зураг 22. ALINX AX309 ПЛИС хавтан.

*ПЛИС – програмчлагддаг логик интеграл схем


АХ309 хавтан нь програмчлагч хүссэн тохируулгаар ажиллах боломжтой TTL түвшний 40 хөлтэй өргөтгөх портыг агуулдаг (Зураг 23). Энэ нь нэмэлтээр АТХ-ыг холбон ажиллуулах боломжийг олгодог. Мөн процессор нь гадаад төхөөрөмжтэй зэрэгцээ ажиллах боломжтой нь хурдтай мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлдэг [36].



Зураг 23. 40 хөлтэй өргөтгөх порт.

МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ ИНТЕРФЕЙС

АХ309 ПЛИС-ийн програм нь АТХ-ыг унших, өгөгдлийг 1Мбит/сек хурдаар компьютерт дамжуулах гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. ПЛИС-ийн програмчлалыг ISE design програм дээр бичсэн (Зураг 24) [38]. Програмын дэлгэрэнгүйг хавсралт №2-оос үзнэ үү.




Зураг 24. ISE design програм


ХҮЛЭЭН АВАХ ПРОГРАМ ХАНГАМЖ

АТХ –ын дохиог компьютерт оруулан Фурье хувиргалт хийж спектрээ гарган авна. Үүний тулд тоон дохионд математик үйлдэл хийх програмыг програмчлалын аль нэг хэл (C++, C#, гэх мэт)-ээр алхам бүрээр нь бичих эсвэл MATLAB, LabVIEW гэх мэт програмуудын бэлэн функцүүдийг хөгжүүлэх замаар боловсруулж болно. LabVIEW програм нь програмчлалыг хурдтай гүйцэтгэх, өөрчлөлт хөгжүүлэлтийг хялбар хийх боломжийг олгодог. Иймд LabVIEW програмын бэлэн функцүүдийг хөгжүүлэн өөрсдийн интерфэйс програмыг бий болгосон [39].

Виртуалаар дохио үүсгэн түүн дээрээ хөрвүүлэлт хийх, эгшин бүрд дохио хүлээн авах програмуудыг боловсруулсан (Зураг 25, 26).




Зураг 25. LabVIEW програм дээр хэд хэдэн синусоид долгионуудыг нэмж, Фурье хувиргалт хийсэн байдал.



Зураг 26. LabVIEW програм дээр дохиог тухайн агшинд хүлээн авах програм

Интерферограмыг хүлээн авч дэлгэцэд харуулах, Фурье хувиргалт (ФХ) хийж спектрийг гаргах, үр дүнг Excel sheet-д хадгалах интерфейс програмыг LabVIEW дээр бичсэн (Зураг 27).



Зураг 27. Интерферограмыг бүртгэх програмын интерфейс.

ТУРШИЛТ БА ҮР ДҮН


ТУРШИЛТЫН БЭЛТГЭЛ АЖИЛ

Оптик элементүүдийн өндөршилийн төвшинг тэгшитгэгч суурь [40]. Суурь нь элемент бүрд өөр өөр өндөртэй байх ёстойг тооцоолон гаргасан (Хүснэгт №7).


Хүснэгт №7.

№	Оптик элементийн нэр	Суурийн өндөр (мм)
1	Нил улаан туяаны үүсгүүр	26.25
2	Хүнхэр толь	35.0
3	Диафрагм	29.0
4	Парабол толь	35.0
5	Долгион хуваагч	41.3
6	ШХТ+толь	0
7	Детектор	35.4



Төхөөрөмжийн элементүүд бүрд тохирох 3 тэнхлэгт хөдлөх боломжтой суурийн загварыг 3 хэмжээсээр FreeCAD програм дээр боловсруулсан. 3 тэнхлэгт хөдлөх учир сууриуд нь дээд болон доод гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Доод суурь нь X тэнхлэгт, дээд хэсэг нь Y тэнхлэгт, дээд хэсэг нь голдоо нүхтэй ба Z тэнхлэгт хөдлөх боломжтойгоор элементүүдтэй холбогдох резбатай төмөр голуудыг суулгахаар тооцож боловсруулсан.



Зураг 28. Гэрлийн үүсгүүрийн X тэнхлэгт хөдлөх суурь



Зураг 29. Гэрлийн үүсгүүрийн Y болон Z тэнхлэгт хөдлөх дээд суурь



Зураг 30. Толины X тэнхлэгт хөдлөх суурь

Зураг 31. Толины Y болон Z тэнхлэгт хөдлөх суурь

Зураг 30, 31 дээрх суурийг хүнхэр толь, диафрагм, парабол толь, долгион хуваагч, детектор зэрэгт ашиглахаар зургийг гаргасан.

FreeCAD програм дээр боловсруулсан зургаар 3D принтерээр элементүүдийг хэвлэсэн.



Зураг 32. Гэрлийн үүсгүүрийн доод суурь



Зураг 33. Гэрлийн үүсгүүрийн дээд суурь



Зураг 34. Гэрлийн үүсгүүрийн суурь



Зураг 35. Толины доод суурь



Зураг 36. Толины дээд суурь



Зураг 37. Толины суурь

Хэвлэсэн суурь дээр элементүүдийг байрлуулан системийг угсарсан (Зураг 38). Элемент тус бүрийн өндөр, хоорондын зайг тохируулагч лазераар нарийн тохируулсан. Спектрометрийн оптик ширээг ДСП* хавтан дээр дагуу болон тууш 5 см-ийн зайтай хэмжээс гаргаж торлон, огтлолцлын цэгүүд дээр бмм диаметртэй нүхэлж бэлтгэсэн.



Зураг 38. Элементүүдийг суурин дээр байрлуулан өндөр, зайг тохируулан байрлуулсан байдал


Спектрометр байрлах өрөөний гэрлийн шуугианыг багасгах зорилгоор нарны гэрэл нэвтэрдэггүй хаалт хийсэн (Зураг 39).

** ДСП – модны үрдсийг тусгай цавуутай хольж шахаж хэвлэсэн хавтан.*




Зураг 39. Гэрэл нэвтэрдэггүй хаалтыг туршилтын өрөөнд байрлуулсан.

Зураг 38, 39-д үзүүлсэн нөхцөлөөр туршилтыг явуулахад детекторт орчны шуугиан ихтэй дохиог хүлээн авсан. Иймд системийн тогтворжилтыг хангахын тулд лазерын лабораторийн өрөөг Физик, Технологийн Хүрээлэнгийн 333 тоотод байгуулсан (Зураг 40). Системд нөлөөлж буй орчны цахилгаан соронзон дохионы шуугианыг багасгах зорилгоор Фарадейн торыг үүсгэсэн.



Зураг 40. Лазерын туршилтын лаборатори

Зэвэрдэггүй ган суурь, суурийг ширээнд бэхлэх соронзон суурь ашиглан, He-Ne лазерыг ашигласан, FTIR-т ашиглагдах Майкольсоны интерферометрийг угсралтыг зураг 41-д, FTIR системийг угсралтыг зураг 42-д үзүүлэв.




Зураг 41. Лазер болон Майкольсоны интерферометрийн систем. 1. He-Ne лазер, 2. Хүнхэр толь, 3. Парабол толь, 4. Долгион хуваагч, 5. Хөдөлгөөнгүй байрлах толь, 6. ШХТ- дээр байрлуулсан толь, 7. Парабол толь



Зураг 42. FTIR спектрометрийн элементүүдийг ширээнд угсарсан байдал

ЛАЗЕРЫН НЭГ ҮҮСГҮҮРИЙН ИНТЕРФЕРОГРАМ

Майкольсоны интерферометрийн зөв ажиллаж буй эсэхийг шалгах арга нь интерферограм ажиглагдаж буй эсэх юм. Иймд He-Ne лазерын интерферограммын симуляцийг хөдөлгөөнт толь 0.1 мм/сек , 0.01 мм/сек , 0.001 мм/сек хурдтай байх үеүдэд хийсэн (Зураг 43).



Зураг 43. Хөдөлгөөнт толь харгалзан зүүн талаас

0.1 мм/сек , 0.01 мм/сек , 0.001 мм/сек хурдтай байх үеийн интерферограммын симуляц

Майкольсоны интерферометрээс гарч буй гэрлийг цулгуй гадаргууд тусган интерферограм үүсэж байгааг шалгасан (Зураг 44).



Зураг 44. Интерферограммын ажиглалтын зураг. Зурвас үүссэн байдал

Систем тохирсны дараа интерферометрээс гарч буй гэрлийг детекторт тусган дохиог осциллоскопоор ажигласан (Зураг 45).




Зураг 45. Хөдөлгөөнт толь харгалзан зүүн талаас

0.1 мм/сек , 0.01 мм/сек , 0.001 мм/сек хурдтай байх үеийн осциллоскоп дээрх интерферограммын дохионы ажиглалтын зураг.


Зураг 43, 45 –аас интерферограмын симуляцийн утга болон хэмжилтийн утгууд нь ижил байгааг харж болно.

NI -LabVIEW програмд АТХ – ын дохиог хүлээн авах програм бичсэн ба зураг 46-д програмын блок схемийг харуулав. Энэ програм нь 8.32 секундэд 2000 өгөгдөл хүлээн авч дэлгэцэд гаргах, цуглуулсан өгөгдлийг Microsoft Office Excel програмд хөрвүүлэн хадгалдаг.



Зураг 46. LabVIEW програм дээр бичсэн дохио хүлээн авах, боловсруулах интерфэйсийн блок схем


Тухайн интерфэйс дээр хөдөлгөөнт толь 0.01мм/сек хурдтай байх үеийн интерферограмын дохиог хүлээн авсныг Зураг 47-т үзүүлэв.



Зураг 47. Хөдөлгөөнт толь 0.01мм/сек хурдтай хөдлөх үед үүсэх He-Ne лазерын интерферограмыг LabVIEW програм дээр харуулсан байдал


ЛАЗЕРЫН ХОС ҮҮСГҮҮРИЙН ИНТЕРФЕРОГРАМ

Фурье хувиргалттай нил улаан туяаны спектрометрийн төхөөрөмжийн хамгийн гол хэсэг нь Майкольсоны интерферометр (МИ) болон түүгээр үүсгэсэн интерферограм дохиог зөв бүртгэх байдаг. Иймд интерферограм дохиог бүртгэх техникийн судалгаа, туршилтыг гүйцэтгэлээ. МИ системийг хоёр ширхэг долгион хуваагчтайгаар угсарч 632.8нм , 0.8млВт (He-Ne лазер) болон 980нм , 0.3млВт (хагас дамжуулагч лазер) долгионы урттай лазерын үүсгүүрүүдийг ашиглан туршсан. Туршилтад ашигласан лазерын цацрагуудын нийлмэл дохионы интерферограмыг MATLAB програм ашиглан загварчилсан (Зураг 48).




Зураг 48. Нийлмэл дохионы интерферограмын загварчлалын үр дүн

Лазерын цацрагуудыг эхний долгион хуваагчийн нэвтрүүлэх болон ойлгох чадварыг ашиглан нэгтгэж хоёр дахь долгион хуваагчаар интерферограмын дохиог үүсгэн детекторт хүлээн авч түүнийгээ компьютерт бүртгэх МИ-ийн системийг угсарч туршсан (Зураг 49).



Зураг 49. Лазерын хос үүсгүүр бүхий МИ-ийн системийн загвар




Зураг 50. Туршилтад ашигласан МИ-ийн систем


- 1) He-Ne лазер 2) диафрагм 3) Хагас дамжуулагчийн лазер 4,5) долгион хуваагч
- 6) хөдөлгөөнгүй толь 7) хөдөлгөөнт толь 8) ШХТ-ийн удирдлага
- 9) Детектор 10) AN706 ATX-ын модуль, ANX309 ПЛИС хавтан

Лазерын цацаргуудын детекторт ирэх эрчмийг хэмжихэд He-Ne лазерын эрчим нь хагас дамжуулагчийн лазерын эрчмээс их байсан тул бууруулах зорилгоор диафрагмыг (зураг 49.2) ашигласан. Интерферограмын дохиог DET10A2 фото-детекторт (Зураг 49.9) хүлээн авсны дараагаар AD7606 аналог-тоон хувиргуур (АТХ) бүхий AN706 модулийг ашиглан хөрвүүлэлт хийн тоон дохио болгон хувиргаж АХ309 ПЛИС хавтангаар дамжуулан компьютерт бүртгэсэн.


Хоёр лазерын нийлмэл цацрагийн интерферограмыг бүртгэсэн туршилтын үр дүн (Зураг 51). Бүртгэгдсэн дохионд ФХ хийн спектрийг харахад хүлээн авсан дохионд хөндлөнгийн нам давтамжийн шуугиан буюу 50 Гц орчмын шуугианы их байсан. Иймд бүртгэсэн дохиог нам давтамжийн шүүлтүүр дамжуулан ФХ хийн интерферограмын спектрийг гарган авсан (Зураг 52).



Зураг 51. Туршилтаар бүртгэсэн хоёр лазерын нийлмэл цацрагийн интерферограм



а)



б)


Зураг 52. Хос лазерын интерферограм боловсруулалтын үр дүн а) Нам давтамжийн шүүлтүүрээр орсон интерферограм, б) Шүүсэн интерферограмын спектр

Туршилтын үр дүнгээс харахад угсарсан МИ систем нь зөв ажиллаж байгааг 2 янзаар үнэлсэн. Дээрх үр дүнгүүдээс харахад загварчлал болон туршилтаар гарган авсан интерферограмууд нь хэлбэр болон бүтцийн хувьд тохирч байна. Мөн туршилтаар бүртгэсэн интерферограмын спектрийн оргилууд нь 634.3нм болон 984.2нм дээр гарсан. Хэмжилтийн алдаа нь тус бүр 0,237% болон 0,428% байгаа нь угсарсан МИ систем дохиог алдаа багатай бүртгэж буйг батлах ба цаашид уг МИ системийг ФХ спектрометрүүд болон өөр конфигурациудад ашиглах боломжтойг харуулсан.

FTIR багажийн нил улаан туяаны үүсгүүрээр өөр өөр гэрлүүдийг ашиглаж туршилт хийсэн. Эхний тохиолдолд бидний өдөр тутмын амьдралдаа хэрэглэдэг улайсдаг ламп нь өөрөөсөө нил улаан туяаг цацаргадаг учир туршилтад 8В, 20Вm -ын лампыг нил улаан туяа нэвтрүүлэх фильтрийн хамт ашигласан (Зураг 53). Хоёр дугаарт 12В, 60Вm -ын галоген ламп болон нил улаан туяа нэвтрүүлэх фильтр ашиглан нил улаан туяаны интерферограмыг гарган авах туршилт хийсэн (Зураг 54).




Зураг 53. Гэрлийн үүсгүүрийн эхний туршилт.



Зураг 54. Галоген ламп болон нил улаан туяаны шүүлтүүрийн зураг.

Хоёр тохиолдолд аль алинд филтрээс гарах гэрлийн эрчим нь хэт бага байсан учраас интерферограмын дохиог гарган авч чадаагүй.

Нил улаан туяаны мужийн PDA10D2 мэдрэгч нь $\sim 220V \rightarrow \pm 12V$ тэжээлийн хувиргагчаар тэжээгддэг ба тэжээлийн хувиргагчийн шуугиан нь гаралтын дохионд нөлөөлж байсан. Иймээс $\pm 12V$ Li-ion батарейн системийг угсарч мэдрэгчийг тэжээж туршсан.



Зураг 55. $\pm 12V$ Li-ion батарейн холболт

ДҮГНЭЛТ

Лазерын спектроскопын технологийн судалгаа суурь судалгааны төслийн хүрээнд Майкольсоны интерферометр дээр суурилсан Фурье хувиргалттай спектрометрийн төхөөрөмжийн оптик системийн тооцоог хийн, техникийн шийдлийг боловсруулан, загварыг угсарч туршсан.

Спектрометрийн төхөөрөмжийн гэрлийн үүсгүүрийн долгионы уртад нийцүүлэн хөдөлгөөнт замыг удирдах, детекторын гаралтын аналог дохиог хувирган компьютерт хүлээн авч, интерферограмыг дэлгэцэд дүрслэх, спектрийг байгуулах, өгөгдлийг хадгалах алгоритмыг боловсруулан хэрэглэгчийн програмын интерфэйсийг бүтээсэн.

Уг ажлаар Майкольсоны интерферометрээс гарч буй интерферограмын дохиог бүртгэх, хувиргахад шаардлагатай судалгаа, тооцоо болон туршилтын үр дүнгээр эрдэм шинжилгээний хурлуудад 3 илтгэл хэлэлцүүлэн, эрдэм шинжилгээний 3 өгүүлэл хэвлүүлж, лазерын (632.8нм, 0.8млВт болон 980нм, 0.3млВт) хоёр үүсгүүр бүхий Майкольсоны интерферометрт суурилсан спектрометрийн төхөөрөмж “Хос лазерын спектрометр RED2” -г зохион бүтээсэн.

Мөн төслийн хүрээнд лазерын туршилтын лабораторийг Физик, технологийн хүрээлэн дээр байгуулсан.

Энэхүү судалгааны ажил нь спектрометрийн дохиог бүртгэх, хувиргах ажлын тооцоо, техникийн шийдлийн эхлэл суурь болсон гэж үзэж байгаа бөгөөд цаашид уг судалгааг гүнзгийрүүлэн явуулах шаардлагатай байна.

HOM 3YŦ

1. D.A.Skoog, F.J.Holler, S.R.Crouch, *Principles of Instrumental Analysis*, 7th edition, Boston, 2016.
2. A.Michelson, E.Morley, *On the Relative Motion of the Earth and the Luminiferous Ether*, American Journal of Science, 34 (1887), 333–345.
3. R.J.Marks II, *Introduction to Shannon Sampling and Interpolation Theory*, Seattle, USA, 1991.
4. Herzberg.G., *Molecular Spectra and Molecular Structure II: Infrared and Raman Spectra of Polyatomic Molecules*, Krieger Publishing, 1991.
5. Nandi Sayantan, *Raman spectroscopy*". 10.13140/RG.2.2.24191.33445, 2021.
6. Laserna.J.J., *An introduction to raman spectroscopy: introduction and basic principles, Raman/Infrared Spectroscopy*, 2014.
7. Long, Derek Albert, *The raman effect: a unified treatment of the theory of raman scattering by molecules*, 2002.
8. McCreery, Richard. L., "Raman spectroscopy for chemical analysis", Vol. 225 (John Wiley & Sons), 2005.
9. Schlucker, Sebastian, Michael.D.S., Scott.W.H., Ira.W.L., *Raman microspectroscopy: a comparison of point, line, and wide-field imaging methodologies*, Analytical Chemistry 75 (16), 4312–4318, 2003.
10. Carey.P.R., "Biochemical Applications of Raman and Resonance Raman Spectroscopies", Academic Press, 1982.
11. P.R.Griffiths, J.A.Haseth, *Fourier Transform – Infrared Spectrometry*, 2nd edition, 2007.
12. B.C.Smith, *Fundamentals of Fourier transform infrared soectroscopy*, 2011.
13. A.Q.Vo, H.He, J.Zhang, S.Martin, R.Chen, M.I.A.Repka, *Application of FT-NIR Analysis for In-line and Real-Time Monitoring of Pharmaceutical Hot Melt Extrusion: a Technical Note*, AAPS PharmSciTech, 2018.
14. D.A.Skoog, D.M.West, F.J.Holler, *Analytical Chemistry: An Introduction (Saunders Golden Sunburst Series)*, 7th edition, 1999.
15. Y.Ozako, W.F.McClure, A.A.Christy, *Near-Infrared Spectroscopy in Food Science and Technology*, 2006.
16. V.Saptari, *Fourier-Transform Spectroscopy Instrumentation Engineering*, Washington,

USA, 2004.

17. D.A.Skoog, J.J.Leary. *Principles of Instrumental Analysis, 4th Ed.*, 1992.
18. N.Jaggy, *Fourier Transform Infrared Spectroscopy*, Handbook of Applied Solid State Spectroscopy, 2007.
19. M.Lucki, L.Bohac, R.Zeleny, *Fiber Optic and Free Space Michelson Interferometer - Principle and Practice*, Optical Sensors - New Developments and Practical Applications, 2014.
